



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Б.Бүрэнжаргал
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/141
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 6.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Албан томилолтоор ажилласан албан хаагчдын хоолны зардлыг давхардуулан нийт 67.0 мянган төгрөгийг илүү олгосон, нийгмийн даатгалын тайланг бодогдсон цалингийн сангаас 587.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө Сумын Засаг даргаар 3 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 85.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040299

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>183,746,643.01</u>	<u>163,906,315.17</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,465,817.38	30,957,261.63
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	39,465,817.38	30,957,261.63
3121	Төгрөг	39,465,817.38	30,957,261.63
31211	Төрийн сангийн харилцах	39,465,817.38	30,957,261.63
33	АВЛАГА	12,600.76	23,649,105.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,600.76	29,100.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	23,620,005.00
35	БАРАА МАТЕРИАЛ	144,268,224.87	109,299,947.78
351	Түүхий эд материал	52,664,358.91	44,839,813.82
35130	Эм боох материал	52,664,358.91	44,839,813.82
354	Хангамжийн материал	91,603,865.96	64,460,133.96
35410	Бичиг хэргийн материал	1,293,800.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	27,174,020.00	17,561,020.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,411,100.00	1,348,100.00
35440	Түлш, шатах тослох материал	965,800.00	-
35450	Барилгын засварын материал	202,890.00	202,890.00
35460	Хүнсний материал	21,630,474.50	15,116,942.50
35470	Бусад хангамжийн материал	38,925,781.46	30,031,181.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,014,923,409.22</u>	<u>1,906,112,617.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,014,923,409.22	1,906,112,617.95
392	Биет хөрөнгө	1,993,050,409.30	1,884,952,617.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,615,871,546.28	1,615,871,546.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(140,823,590.40)	(179,042,147.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,012,896.55	69,012,896.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,352,930.01)	(38,970,129.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	505,711,149.01	545,155,128.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(114,879,870.04)	(209,371,766.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,604,100.00	59,003,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,431,367.12)	(22,446,562.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,306,459.80	62,306,459.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,967,984.77)	(16,566,606.93)
393	Биет бус хөрөнгө	21,872,999.92	21,160,000.04
39301	Програм хангамж	1,690,000.00	1,690,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(625,000.08)	(1,337,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,808,000.00	20,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,198,670,052.23</u>	<u>2,070,018,933.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>3,324,079.21</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,324,079.21
413	Өглөг	-	3,324,079.21

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,324,079.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,198,670,052.23</u>	<u>2,066,694,853.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,198,670,052.23	2,066,694,853.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,284,554.00	435,284,554.00
51101	Өмч: - төрийн	435,284,554.00	435,284,554.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,673,965,316.53	1,541,990,118.21
51210	Өмнөх үеийн үр дүн	1,673,965,316.53	1,673,965,316.53
51220	Тайлант үеийн үр дүн	-	(131,975,198.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,420,181.70	89,420,181.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,198,670,052.23</u>	<u>2,070,018,933.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,180,087,634.06	921,415,810.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,513,478.06	59,622,510.58
120	Нийтлэг татварын бус орлого	302,513,478.06	59,622,510.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	877,574,156.00	861,793,300.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	659,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	659,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,275,686.00	72,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,275,686.00	72,839,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	799,639,470.00	788,954,100.12
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	799,639,470.00	788,954,100.12
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,032,698,507.23	1,053,391,009.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,032,698,507.23	1,053,391,009.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,030,502,087.23	1,052,582,467.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,147,403.62	568,926,726.87
210101	Үндсэн цалин	280,306,460.39	351,153,184.10
210102	Нэмэгдэл	159,142,169.36	153,354,896.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,295,778.00	6,076,126.25
210104	Урамшуулал	61,402,995.87	58,342,519.58
210105	Гэрээт ажлын хөлс	25,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,359,046.24	73,302,968.00
210201	Тэтгэврийн даатгал	47,052,948.00	47,867,184.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,078,599.00	6,275,571.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,063,019.00	5,190,337.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,378.24	1,118,733.00

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	10,160,102.00	12,851,143.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,149,180.00	65,030,658.00
210301	Гэрэл, цахилгаан	3,996,880.00	4,848,930.00
210302	Түлш, халаалт	58,203,900.00	60,148,728.00
210303	Цэвэр, бохир ус	948,400.00	33,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,724,848.00	65,913,264.62
210401	Бичиг хэрэг	4,775,800.00	4,407,960.00
210402	Тээвэр, шатахуун	24,064,920.00	21,541,646.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,315,000.00	3,080,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,569,128.00	14,827,218.03
210408	Бараа материал акталсны зардал	-	22,056,440.59
2105	Нормативт зардал	123,990,348.75	100,551,129.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,105,115.75	84,390,197.26
210502	Хоол, хүнс	9,885,233.00	16,160,932.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,300,450.00	6,807,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,511,950.00	1,894,000.00
210604	Урсгал засвар	17,788,500.00	4,913,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,240,000.00	1,125,000.00
210702	Дотоод албан томилолт	2,240,000.00	1,125,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,795,980.00	3,037,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	893,780.00	1,436,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	52,200.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,300.00	105,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	15,750.00
210807	Газрын төлбөр	102,700.00	208,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,794,830.62	167,888,670.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,483,000.00	12,234,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,311,830.62	155,654,470.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,420.00	808,542.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,196,420.00	808,542.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,196,420.00	808,542.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>147,389,126.83</u>	<u>(131,975,198.32)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>147,389,126.83</u>	<u>(131,975,198.32)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	920,837,856.00	838,173,295.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	920,837,856.00	838,173,295.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	659,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	659,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,275,686.00	72,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,275,686.00	72,839,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	842,903,170.00	765,334,095.12
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	842,903,170.00	765,334,095.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	883,683,208.62	839,282,150.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	883,683,208.62	839,282,150.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	881,486,788.62	838,473,608.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,147,403.62	568,926,726.87
210101	Үндсэн цалин	280,306,460.39	351,153,184.10
210102	Нэмэгдэл	159,142,169.36	153,354,896.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,295,778.00	6,076,126.25
210104	Урамшуулал	61,402,995.87	58,342,519.58
210105	Гэрээт ажлын хөлс	25,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,371,647.00	73,319,468.00
210201	Тэтгэврийн даатгал	47,052,948.00	47,867,184.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,078,599.00	6,275,571.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,063,019.00	5,190,337.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,979.00	1,135,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,160,102.00	12,851,143.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,102,180.00	65,030,658.00
210301	Гэрэл, цахилгаан	3,996,880.00	4,848,930.00
210302	Түлш, халаалт	56,156,900.00	60,148,728.00
210303	Цэвэр, бохир ус	948,400.00	33,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,552,228.00	27,358,546.00
210401	Бичиг хэрэг	2,550,200.00	2,475,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,960,100.00	18,310,846.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,315,000.00	3,080,000.00
210404	Ном, хэвлэл	70,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,881,000.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,775,928.00	2,742,700.00
2105	Нормативт зардал	116,715,900.00	77,033,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,076,440.00	65,750,400.00

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	20,039,460.00	9,647,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,600,000.00	1,636,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,202,550.00	7,099,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	275,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,935,450.00	2,249,700.00
210604	Урсгал засвар	17,992,100.00	4,850,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,240,000.00	1,125,000.00
210702	Дотоод албан томилолт	2,240,000.00	1,125,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,671,880.00	6,198,710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,061,780.00	2,197,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	52,200.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,300.00	105,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	15,750.00
210807	Газрын төлбөр	102,700.00	208,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,707,900.00	2,400,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,483,000.00	12,381,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,483,000.00	12,381,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,196,420.00	808,542.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,196,420.00	808,542.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,196,420.00	808,542.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,154,647.38</u>	<u>(1,108,855.75)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,960,000.00	7,399,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,960,000.00	7,399,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,960,000.00	7,399,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,960,000.00	7,399,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,960,000.00)</u>	<u>(7,399,700.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,194,647.38	(8,508,555.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,271,170.00	39,465,817.38
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,465,817.38	30,957,261.63

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,526,576,189.70	2,051,280,925.40
Тайлант үеийн үр дүн	-	-	147,389,126.83	147,389,126.83
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,673,965,316.53	2,198,670,052.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,673,965,316.53	2,198,670,052.23
Тайлант үеийн үр дүн	-	-	(131,975,198.32)	(131,975,198.32)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,541,990,118.21	2,066,694,853.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	977,445,500.00	845,873,308.87	131,572,191.13	86.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	977,445,500.00	845,873,308.87	131,572,191.13	86.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	977,445,500.00	845,873,308.87	131,572,191.13	86.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,307,000.00	568,926,726.87	105,380,273.13	84.4
210101	Үндсэн цалин	419,728,700.00	351,153,184.10	68,575,515.90	83.7
210102	Нэмэгдэл	201,101,800.00	153,354,896.94	47,746,903.06	76.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,500,000.00	6,076,126.25	(1,576,126.25)	135.0
210104	Урамшуулал	48,976,500.00	58,342,519.58	(9,366,019.58)	119.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,622,100.00	73,319,468.00	12,302,632.00	85.6
210201	Тэтгэврийн даатгал	58,223,300.00	47,867,184.00	10,356,116.00	82.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,849,300.00	6,275,571.00	573,729.00	91.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,479,600.00	5,190,337.00	289,263.00	94.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,370,100.00	1,135,233.00	234,867.00	82.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,699,800.00	12,851,143.00	848,657.00	93.8

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,839,200.00	65,030,658.00	808,542.00	98.8
210301	Гэрэл, цахилгаан	5,657,000.00	4,848,930.00	808,070.00	85.7
210302	Түлш, халаалт	60,149,200.00	60,148,728.00	472.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	33,000.00	33,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	30,639,100.00	27,358,546.00	3,280,554.00	89.3
210401	Бичиг хэрэг	2,475,000.00	2,475,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	20,129,700.00	18,310,846.00	1,818,854.00	91.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,160,000.00	3,080,000.00	80,000.00	97.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,874,700.00	750,000.00	1,124,700.00	40.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,700.00	2,742,700.00	257,000.00	91.4
2105	Нормативт зардал	83,900,900.00	77,033,800.00	6,867,100.00	91.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,750,400.00	65,750,400.00	-	100.0
210502	Хоол, хүнс	14,400,200.00	9,647,400.00	4,752,800.00	67.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,300.00	1,636,000.00	2,114,300.00	43.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,937,400.00	14,499,400.00	438,000.00	97.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	438,000.00	-	438,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,249,700.00	2,249,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	12,249,700.00	12,249,700.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,025,000.00	1,125,000.00	900,000.00	55.6
210702	Дотоод албан томилолт	2,025,000.00	1,125,000.00	900,000.00	55.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,300,300.00	6,198,710.00	101,590.00	98.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,250,000.00	2,197,660.00	52,340.00	97.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	105,000.00	15,000.00	87.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	15,750.00	34,250.00	31.5
210807	Газрын төлбөр	208,000.00	208,000.00	-	100.0

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,400,300.00	2,400,300.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,874,500.00	12,381,000.00	1,493,500.00	89.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,874,500.00	12,381,000.00	1,493,500.00	89.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	977,445,500.00	837,364,753.12	140,080,746.88	85.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,839,200.00	72,030,658.00	808,542.00	98.9
132001	Орон нутгийн төсвөөс	72,839,200.00	72,030,658.00	808,542.00	98.9
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	865,140,500.00	765,334,095.12	99,806,404.88	88.5
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	865,140,500.00	765,334,095.12	99,806,404.88	88.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	39,465,800.00	-	39,465,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	39,465,817.38	(39,465,817.38)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	30,957,261.63	(30,957,261.63)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	23.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-	100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,710.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22,056.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 654.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 654.5 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 16,523.2 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд 22,056.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгахдаа акталж устгасны зардалд бус эмийн зардалд бүртгэсэн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин, НДШ-ийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Цалин, НДШ-ийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас 587.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" 17.1.3 "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхий журнал дахь Цалин, НДШ-ийн зардлыг цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын тайлантай тулган хяналт тавих

2. Томилолтын зардалтай холбоотой

Илрүүлэлт: Тайлант хугацаанд 6 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 35 хоногийн хоолны зардал 67.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулах

3. Шатахууны тооцоололтой холбоотой

Илрүүлэлт: Тээвэр, шатахууны зардлын зарцуулалтыг нярвын тайлангаас хөөн шалгахад албан хэрэгцээнд ашиглаж байгаа автомашины жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөж, спидометрийн заалтыг тэмдэглээгүй байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Жишиг норм батлах тухай" журамд заасан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг холбогдох журмын дагуу бөглөж, норм баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материал акталж устгахдаа буруу дансанд бүртгэсэн	1	22,056.4			1	22,056.4	1	22,056.4		
Дүн	1	22,056.4			1	22,056.4	1	22,056.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин, НДШ-ийн зардлыг нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан	1	587.5					1	587.5
Томилолтын хоолны зардлыг давхардуулж олгосон	1	67.0					1	67.0
Жолоочийн тооцоо хуудсыг дутуу бөглөсөн	1	-					1	-
Дүн	3	654.5					3	654.5

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			